



Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлж буй иргэдээс авсан 2023 оны 4-р сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын арга ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэсийн үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Хүснэгт:1

| Асуулт:1 | | | |
|-----------|---------|--------------|--------|
| | | Иргэдийн тоо | Хувь |
| Таны хүйс | Эрэгтэй | 75 | 30% |
| | Эмэгтэй | 175 | 70% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:1




Дүгнэлт: Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авахад 250 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 70% эмэгтэй, 30% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.



Хүснэгт:2

| Асуулт:2 | | | |
|----------|-------------|--------------|--------|
| | | Иргэдийн тоо | Хувь |
| Таны нас | 16-21 | 2 | 0.8% |
| | 22-30 | 33 | 13.2% |
| | 31-40 | 71 | 28.4% |
| | 41-50 | 77 | 30.8% |
| | 50-ээс дээш | 67 | 26.8% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:2



Дүгнэлт: Насны хувьд авч үзвэл 16-21 насны 2 даатгуулагч, 22-30 насны 33 даатгуулагч, 31-40 насны 71 даатгуулагч, 41-50 насны 77 даатгуулагч, 50-иас дээш насны 67 даатгуулагч судалгаанд хамрагдсан байна. Нийгмийн даатгалын байгууллагаар 4-р сард үйлчлүүлсэн даатгуулагчдын ихэнх хувь нь 41-50 насныхан буюу 30.8% байна.



Хүснэгт:3

| Асуулт:3 | | | |
|-------------------------------------------------|-----------------|--------------|--------|
| | | Иргэдийн тоо | Хувь |
| Та хэдэн тоотын байцаагчаас үйлчилгээ авсан бэ? | 1 | 33 | 1.2% |
| | 2 | 11 | 7.6% |
| | 3 | 29 | 8% |
| | 4 | 23 | 14.4% |
| | 5 | 13 | 6% |
| | 6 | 30 | 7.2% |
| | 7 | 21 | 11.6% |
| | 8 | 1 | 6.4% |
| | 9 | 13 | 6.4% |
| | 10 | 26 | 11.2% |
| | Угтах үйлчилгээ | 50 | 20% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:3




Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний хэсэгт нийт 10 байцаагч, угтах үйлчилгээний ажилчид зөвлөгөө мэдээлэл үйлчилгээг иргэд, даатгуулагчдад хүргэн ажилладаг.



Хүснэгт:4

| Асуулт:4 | | | |
|----------------------------------------------------|--------------------------------------------------------|------------|---------------|
| | Иргэдийн тоо | Хувь | |
| Та яг одоо ямар үйлчилгээ авахаар ирсэн бэ? | Тэтгэвэртэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ | 70 | 28% |
| | Тэтгэмжтэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ | 53 | 21.2% |
| | Эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээлэл, үйлчилгээ | 45 | 18.0% |
| | Сайн дурын даатгалтай холбоотой мэдээлэл, үйлчилгээ | 51 | 20.4% |
| | Нийгмийн даатгалын тайлантай холбоотой үйлчилгээ | 7 | 2.8% |
| | Лавлагаа | 13 | 5.2% |
| | Бусад | 11 | 4.4% |
| | Нийт | 250 | 100.0% |

График:4




Дүгнэлт: Нийт 250 даатгуулагч судалгаанд хамрагдснаас 3-р сард тэтгэврийн даатгалтай холбоотой үйлчилгээ авахаар 59 даатгуулагч (23,6%) бол 4-р сард тэтгэврийн даатгалтай холбоотой үйлчилгээ авахаар 70 даатгуулагч (28%) болж өссөн үзүүлэлттэй харагдаж байна. 3-р сард тайлантай холбоотой үйлчилгээ авахаар 19 даатгуулагч (7,6%), 4-р сард 7 даатгуулагч (2,8%) болж буурсан үзүүлэлттэй харагдаж байна.



Хүснэгт:5

| | | Асуулт:5 | |
|---------------------------------------------------|-------------------|--------------|---------------|
| | | Иргэдийн тоо | Хувь |
| Та үйлчилгээ авахын тулд хэдэн минут хүлээсэн бэ? | Шууд үйлчлүүлсэн | 190 | 76% |
| | 5-15 минут | 45 | 18.0% |
| | 15-30 минут | 12 | 4.8% |
| | 30 минутаас 1 цаг | 1 | 0.4% |
| | 1-2 цаг | 2 | 0.8% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:5




Дүгнэлт: Хүлээлгийн хугацааны хувьд 3-р сард даатгуулагчдын 43.6% буюу 109 даатгуулагч нийгмийн даатгалын үйлчилгээ авахын тулд шууд үйлчлүүлсэн бол 4-р сард 76% буюу 190 даатгуулагч шууд үйлчлүүлсэн байна. Өмнөх сартай харьцуулахад шууд үйлчилгээ авсан даатгуулагчдын тоо өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Энэ нь манай байгууллагын хувьд даатгуулагчдад үйлчилгээ үзүүлэхэд хүлээлгийн хугацаа дээр ямар нэгэн хүндрэл, чирэгдэлгүй илүү хурдан шуурхай үйлчилж байгаа нь харагдаж байна



Хүснэгт:6

| Асуулт:6 | | Иргэдийн тоо | Хувь |
|--------------------------------------------------------------------|--------------------|--------------|--------|
| Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? | Бүрэн өгч чадсан | 245 | 98% |
| | Хангалтгүй | 1 | 0.4% |
| | Бүрэн өгч чадаагүй | 3 | 1.2% |
| | Маш муу | 1 | 0.4% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:




Дүгнэлт: Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуулгын хувьд нийт судалгаанд оролцогчдын 98% буюу 245 даатгуулагч “Бүрэн өгч чадсан” гэсэн хариулт өгсөн бол 1.2% буюу 3 даатгуулагч бүрэн өгч чадаагүй гэж хариулсан. Харин 0,4% буюу 1 иргэн “Хангалтгүй” байна гэсэн үнэлгээ өгсөн. 1 даатгуулагч буюу 0.4% маш муу мэдээлэл өгсөн гэж үнэлсэн байна.



Хүснэгт:7

| Асуулт:7 | | | |
|---------------------------------------------------------|----------|--------------|--------|
| | | Иргэдийн тоо | Хувь |
| Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? | Маш сайн | 144 | 57.6% |
| | Сайн | 104 | 41.6% |
| | Дунд | 1 | 0.4% |
| | Муу | 1 | 0.4% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:7




Дүгнэлт: Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгын хувьд 57.6% буюу 144 даатгуулагч байцаагчийн мэргэжлийн ур чадварыг “Маш сайн” гэж үнэлсэн бол 41.6% буюу 104 даатгуулагч “Сайн” гэж үнэлсэн байна. Бусад даатгуулагчдын хувьд 0.4% буюу 1 даатгуулагч “Дунд” гэж үнэлсэн ба 0.4% буюу 1 даатгуулагчийн хувьд байцаагчийн ур чадварыг маш муу гэж үнэлсэн байна.



Хүснэгт:8

| Асуулт:8 | | | |
|--------------------------------------------------------------------------------------------|---------------------|--------------|--------|
| | | Иргэдийн тоо | Хувь |
| Нийгмийн даатгалын хэлтсийн ажилчдын ёс зүй, зан харьцаа, хандлагыг хэрхэн үнэлж байна вэ? | Маш өндөр ханамжтай | 135 | 54% |
| | Сэтгэл ханамжтай | 114 | 45.6% |
| | Маш муу | 1 | 0.4% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:8




Дүгнэлт: Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын хувьд хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултын хувьд 54.0% буюу нийт 135 даатгуулагч “Маш өндөр ханамжтай” бол 45.6% буюу 114 даатгуулагч “Сэтгэл ханамжтай” гэсэн хариулт өгсөн байна. Нийгмийн даатгалын хэлтсийн ажилчдын ёс зүй, зан харилцаа, хандлагад 0.4% буюу 1 даатгуулагч сэтгэл маш муу гэж үнэлсэн байна.



Хүснэгт:9

| Асуулт:9 | | | |
|--------------------------------------------------------|----------|--------------|--------|
| | | Иргэдийн тоо | Хувь |
| Байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ? | Маш сайн | 140 | 56.0% |
| | Сайн | 109 | 43.6% |
| | Дунд | 0 | 0% |
| | Муу | 1 | 0.0% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:9




Дүгнэлт: Байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ? гэсэн асуулгын хувьд 3-р сард 53.2% 133 даатгуулагч маш сайн гэж хариулсан бол 56.0% буюу 140 даатгуулагч сэтгэл ханамж “Маш сайн” хариулсан өмнөх сараас 2.8% өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Харин 43.6% буюу 109 даатгуулагч сэтгэл ханамж “Сайн” гэсэн хариулт өгсөн байна. Бусад даатгуулагчийн хувьд 0.4% буюу даатгуулагч байцаагчийн үйлчилгээнд өгсөн сэтгэл ханамж “Маш муу” гэж хариулт тус тус өгсөн байна.



Хүснэгт:10

| Асуулт:10 | | Иргэдийн тоо | Хувь |
|-----------------------------------------------------------------------------------------------|----------|--------------|--------|
| Нийгмийн даатгалын үйлчилгээг олон дамжлагагүй 1 ажилтнаас авдаг болсныг та хэрхэн үнэлэх вэ? | Маш сайн | 145 | 58% |
| | Сайн | 103 | 41.2% |
| | Дунд | 1 | 0.4% |
| | Муу | 1 | 0.4% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:10



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээг олон дамжлагагүй 1 ажилтнаас авдаг болсныг та хэрхэн үнэлэх вэ? асуулгыг авч үзвэл даатгуулагчдын 58% буюу 145 даатгуулагч “Маш сайн”, 41.2% буюу 103 даатгуулагч “Сайн”, 0.8% буюу 2 даатгуулагч “Дунд” үнэлгээ өгсөн байна.



Хүснэгт:11

| Асуулт:11 | | | |
|-----------------------------------------------------------------------------------------|---------------|-----------------|---------------|
| | | Иргэдийн тоо | Хувь |
| Та нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын тулд хэдэн удаа ирэх шаардлагатай болдог вэ? | 1 удаа | 185 | 74% |
| | 2 удаа | 50 | 20% |
| | 3-4 удаа | 13 | 5.2% |
| | 5-с дээш удаа | 0 | 0.0% |
| | Маш олон удаа | 2 | 0.8% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:11




Дүгнэлт: Та нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын тулд хэдэн удаа ирэх шаардлагатай болдог вэ? гэсэн асуултад нийт 250 даатгуулагч хамрагдснаас 3 сард 158 даатгуулагч 1 удаа ирэх шаардлага гарсан гэсэн бол 3 сард 185 даатгуулагч болж өссөн байна. Харин 3 сард 1 удаа үйлчилгээ авахын тулд 3-4 удаа ирэх шаардлага гарсан 15 даатгуулагч байсан бол 4-р сард 13 даатгуулагч болж буурсан байна. Мөн 3-р сард 5-с дээш удаа 4, маш олон удаа гэсэн хариултыг 3 даатгуулагч бол 4-р сард 5-с дээш ирэх шаардлага гарсан гэсэн даатгуулагч байгаагүй бол маш олон удаа гэсэн хариултыг 2 даатгуулагч өгсөн байна. Иймд даатгалын үйлчилгээ авахаар ирсэн даатгуулагчдыг олон дахин явуулах асуудал буурч байгааг харуулж байна.



Хүснэгт: 12

| Асуулт: 12 | | |
|--------------------------------------------------------------------|--------------|-----------|
| | Иргэдийн тоо | Хувь |
| Нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлнэ үү? | Маш сайн | 86 34.4% |
| | Сайн | 132 52.8% |
| | Дунд | 29 11.6% |
| | Муу | 3 1.2% |
| Нийт | 250 | 100.0% |

График: 12




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлнэ үү? Гэсэн асуулгын хувьд үйлчилгээний ил тод нээлттэй байдлын хувьд даатгуулагчдын 34.4% буюу 86 даатгуулагч “Маш сайн”, 52.8% буюу 132 даатгуулагч нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдалд “Сайн”, 11.6% буюу 29 даатгуулагч үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлэхдээ “Дунд”, 1.2% буюу 3 даатгуулагч муу гэж хариулсан байна.



Хүснэгт:13

| | | Иргэдийн тоо | Хувь |
|----------------------------------------------------------------------------------------|------|--------------|--------|
| Ажилтнуудын буруутай үйлдлээс болж таньд ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирч байсан уу? | Тийм | 15 | 3.2% |
| | Үгүй | 235 | 96.8% |
| Нийт | | 250 | 100.0% |

График:13



Дүгнэлт: Даатгуулагчдад ямар нэгэн хүндрэл чирэгдэл учруулж, хүнд суртал гаргаж байсан эсэх асуултанд нийт даатгуулагчийн 96.8% буюу 242 даатгуулагч “үгүй” гэсэн хариулт өгсөн. Үүнээс 3.2% буюу 8 даатгуулагч дээрх асуултанд “тийм” гэсэн хариулт өгсөн байна. Даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээ авахад ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирсан нь бага байна.



Хүснэгт:14

| Асуулт:14 | | |
|-----------------------------------------------------------------------------------|--------------|--------------|
| | Иргэдийн тоо | Хувь |
| Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод орчин нөхцөл, тав тухыг хэрхэн үнэлж байна вэ? | Маш сайн | 59 23.6% |
| | Сайн | 102 40.8% |
| | Боломжийн | 84 33.6% |
| | Муу | 5 2.0% |
| Нийт | 250 | 100.0% |

График:14



Дүгнэлт: Тав тух, орчин нөхцөлийн хувьд иргэд даатгуулагчдын эерэг сэтгэгдэлтэй буюу хэлтсийн зохион байгуулалт дотоод орчин нөхцөлийг 3-р сард 27.2% буюу 68 “Маш сайн” бол 4-р сард 23.6% буюу 59 даатгуулагч маш сайн гэж үнэлсэн нь өмнөх сарын үзүүлэлтээс 3.6% буурсан байна. Харин 3-р сард 63 даатгуулагч буюу 25.2% боломжийн гэж хариулсан бол 4-р сард 84 даатгуулагч буюу 33.6% боломжийн гэж хариулсан байна. Иргэдэд тав тухтай байлгах, орчин нөхцлийг сайжруулах тал дээр анхаарах шаардлагатай гэж үзэж байна.



Асуулт 15. Таньд нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах ямар нэгэн санал, хүсэлт байвал чөлөөтэй бичнэ үү?

1. Маш сайн.
2. Баярлалаа.
3. Орхон аймгаас бусад аймаг хотоос лавлагаа авах гэж хүсэлт бичсэн. /УБ хот Баянгол дүүрэг/ буцааж хариу ирээгүй.
4. Танай хамт олонд баярлалаа.
5. НДШ нөхөн төлдөг бол маш сайн байна.
6. Маш сайхан үйлчилсэнд талархлаа. Түмэн олны төлөө сайхан зүйл хийжээ.
7. НД дамжин өөр аймгаас авч байгаа лавлагаа хугацаа алдаж байна.
8. Та бүхэндээ түргэн шуурхай үйлчилсэнд баярлалаа. Ажлын амжилт хүсье.
9. Үйлчилгээ маш сайн хурдан авч чадлаа баярлалаа та нартаа.
10. Нийгмийн даатгалын хамт олон болон Одонтунгалаг байцаагчдаа ажлын амжилт хүсье.
11. Үйлчилгээ сайн 4-н номерын ажилтандаа маш их баярлалаа. Ажлын амжилт хүсье. Харилцаа хандлага маш сайн байлаа.
12. Үйлчилгээ аваад сэтгэл хангалуун байна.
13. Баярлалаа ажлын амжилт хүсье.
14. Маш их туслаж зөвлөгөө өгсөнд баярлалаа.
15. Сэтгэл ханамж өндөр.
16. Хөнгөн шуурхай үйлчилсэнд баярлалаа.
17. Маш сайн байдаг. Хамт олонд ажилд нь ажлын амжилт хүсье.
18. НДШ-ийн талаар богино хэмжээний шторк хийж тв-ээр цацах.
19. Сэтгэл ханамж маш сайн.
20. Цахим системийг улам сайжруулах.
21. Ёс зүй, харилцаа сайн хүн бүрт тайлбар мэдээлэл сайн өгч байна.
22. Сайн үйлчилсэнд баярлалаа.
23. Зарим ажилтан нь дугарч ядсан их зантай байдаг.
24. 7 жил 5 жил болгох /нэн яаралтай/ НД-ын хуулийг яаралтай шинэчил.
25. Сэтгэл ханамж 100%.
26. Хандлагаас харилцаа үүснэ. Хариу олгох үйлчилгээ маш сайн хандсан. Мөн угтах үйлчилгээ маш сайн хандсанд баярлалаа.




27. Маш сайн хурдан шуурхай байсан. Баярлалаа.
28. Сэтгэл ханамжтай үйлчлүүлсэндээ баяртай байна.
29. Амжилт хүсье.
30. Түргэн шуурхай найрсаг үйлчилсэнд баярлалаа.
31. Үйлчилгээнд сэтгэл өндөр байна. Баярлалаа.
32. Мэдэхгүй зүйлийг асуухад их сайхан тайван тайлбарлаж өгдөгт нь их баярлаж байдаг. Тодорхой ойлгуулж өгдөгт нь та нартаа баярлалаа.
33. Үйлчлүүлэгчид ямар нэгэн мэдэгдлийг мессежээр хүргэх.
34. Нийгмийн даатгалын үйлчилгээг маш ойлгомжтой авахыг хүсдэг. /Хууль тогтоомжийн өөрчлөлтийг/
35. Ажлын амжилт хүсье.
36. Лист 100% цахим болгомоор байна.
37. ХЧТА листний мөнгийг сарын сүүлийн 1 өдөр хийчихдэг нь сарын мэдээ гаргахад хүндрэлтэй байдаг.
38. Маш түргэн шуурхай үйлчиллээ. Баярлалаа.
39. Онлайн /Цахим/ лист Б-НД-21 тайлан ажилтнаар сонголт /хийж хэвлэх боломжгүй





16. Байцаагчийн буруутай үйлдлээс болж ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирч байсан уу? гэсэн асуултыг авч үзэхэд:


График:16



Дүгнэлт: Дээрх графикаас харахад 3-р сард ихэнх байцаагч ажилтнуудын буруутай үйлдлээс болж хүндрэл, чирэгдэл тодорхой хэмжээгээр учирсан бол 4-р сард үзүүлэлт огт өөрчлөгдөөгүй байгаа нь харагдаж байна.

17. Байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын үнэлэмжийн хувьд дараах үзүүлэлттэй байна:

График:17




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа 1, 6, 10 номертой байцаагчийн үйлчилгээнд маш сайн гэж 14 даатгуулагч хариулсан бол 1 номертой байцаагчийн үйлчилгээнд 19 даатгуулагч сайн гэж хариулсан байна.



18. Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуултыг авч үзэхэд:


График:18



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуултын хувьд 4 дугаартай байцаагчийн хувьд 18 даатгуулагч хүссэн мэдээллийг бүрэн өгч чадсан бол 5 даатгуулагч хангалтгүй гэж үнэлгээ өгсөн байна.

19. Байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултыг авч үзэхэд:

График:19




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа байцаагчийн мэргэжлийн ур чадварыг үнэлэхдээ 6 дугаартай байцаагчийн хувьд 18 даатгуулагч маш сайн, 12 даатгуулагч сайн гэж үнэлсэн бол 1, 10 дугаартай байцаагчийн мэргэжлийн ур чадварыг үнэлэхдээ 16 даатгуулагч маш сайн, 26 даатгуулагч сайн гэж үнэлсэн байна.



20. Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулт дараах үзүүлэлттэй байна.

График:20




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэдийн байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулгын хувьд 4 дугаартай байцаагчаас үйлчилгээ авч байгаа 18 даатгуулагч маш сайн, 5 даатгуулагч сэтгэл ханамж сайн гэж хариулсан байна. 1 дугаартай байцаагчийн үйлчилгээнд 12 даатгуулагч сэтгэл ханамж маш сайн 21 даатгуулагч сайн гэж үнэлсэн байна. Үүнээс үзэхэд нийгмийн даатгалын үйлчилгээг авч буй иргэдийн хувьд үйлчилгээнд сэтгэл ханамжтай байна.

Сэтгэл ханамжийн индексийн үнэлгээ:

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлүүлэхдээ 1-10 гэсэн Лайкерьтын шкал (хэмжүүр) ашигласан болно. Уг индексийн агуулгын хувьд 9.00-10.00 байвал хэрэглэгч маш сэтгэл ханамжтай бөгөөд энэ нь бодит нөхцөл байдал дээр тийм ч олон тохиолддоггүй онолын түвшиний ойлголт юм. 8.00- 8.99 хооронд тохиолдолд сэтгэл ханамжтай ба байгууллагууд энэ түвшинд байхад харьцангуй санаа зовох зүйл бага байдаг. Харин 6.00-8.00 хооронд хэрэглэгчийн сэтгэл ханамж дээгүүр түвшинд байгаа бөгөөд цаашид нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлсэн мэдээлэл юм. Харин 5.99-өөс доош байгаа бол энэ




Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултад 3-р сард 2 дугаартай байцаагч 8.82 үнэлгээ авсан бол 4-р сард 9.09 болж өссөн байна. Харин 7 дугаартай байцаагч 3-р сард 8.97 байсан бол 4-р сард 8.29 үнэлгээтэй болж буурсан үзүүлэлттэй байна.


Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? Гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 3-р сард 1, 6, 8, 9, 10 дугаартай байцаагч нар 10.0 үнэлгээтэй байсан бол 4-р сард 2, 4, 5, 8, 9, 10 дугаартай байцаагч нар 10.0 үнэлгээтэй байна.




Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 3-р сард 2 дугаартай байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлага 8.68 байсан бол 4-р сард 9.32 болж өссөн үзүүлэлттэй байна. Харин 9 дугаартай байцаагч 3-р сард 9.06 байсан бол 4-р сард 8.85 болж буурсан үзүүлэлттэй байна.


Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 3-р сард 4 дугаартай байцаагчийн хувьд 8.68 байсан бол 4-р сард 9.46 болж өссөн үзүүлэлттэй байна. Харин 5 дугаартай байцаагч 3-р сард 8.83 байсан бол 4-р сард 8.27 болж буурсан үзүүлэлттэй байна.



Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дундаж индекс



Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 4 сарын үйлчилгээ, орчин нөхцлийг үнэлэх судалгааны 10-н асуултыг индекслэхэд **8.77** байна.

Судалгааны нэгтгэл хийсэн: Н.Оюун-Эрдэнэ/...../